

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН
2017 ОНЫ 2-Р УЛИРАЛД ХЭРЭГЖҮҮЛСЭН
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН**

2017.06.25.

Арвайхээр сум

Тус цагдаагийн газрын алба хаагчид нь Цагдаагийн Ерөнхий Газраас 2017 онд дэвшүүлсэн зорилт, Цагдаагийн Ерөнхий Газрын даргын тушаалаар 2009 онд баталсан "Цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандарт", "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам", холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагатай түншлэлийн холбоо тогтоож, хамтран ажиллах, алба хаагчдын сахилга ёс зүй, ажлын хариуцлага, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, ая тохитой орчинд ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар

Энэ хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газраас гаргасан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тогтоол, эрх зүйн бичиг баримт, Хууль зүй дотоод хэргийн сайд, ЦЕГ-ын даргын “Цагдаагийн байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн” дээр өгсөн үүрэг ажлын чиглэл, дэд дарга нарын өгсөн үүрэг даалгавар, тушаал, шийдвэрийг бие бүрэлдэхүүнд танилцуулж, үр дүнгийн гэрээнд тусгуулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Цагдаагийн газраас “2017 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”, “Сургалтын төлөвлөгөө”, “Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”, “Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө”, “Дотоод аюулгүй байдлыг хангах ажлын төлөвлөгөө”, “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах удирдамж төлөвлөгөө”, “Урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө”, зэрэг баримт бичгүүдийг батлан гаргаж хэлтэс тасаг, хэсгийн төлөөлөгч нарт хүргүүлсэн. Цагдаагийн газрын хэлтэс, тасаг, хэсгийн төлөвлөгөөнд алба хаагчдаас шинэ санал санаачилга гаргаж ажиллах талаар тусгаж хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Хоёр. Алба хаагч ажилтны нийгмийн баталгааг хангах чиглэлээр

Тус газрын алба хаагчдын гэр бүлд байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчдын ажлын онцлогийг ойлгуулж танилцуулах, тэдэнтэй уулзалт, ярилцлага зохион байгуулж санал бодлыг нь сонсох, гэр бүлийн таатай уур амьсгал бүрдүүлэх, Эх үрсийн баярыг байгууллагын хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх зорилгоор 2017 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Тарагт сумын “Өгөөмөр” рашаан сувилалд алба хаагчдын гэр бүл, үр хүүхдүүд зэрэг 280 гаруй хүнийг хамруулсан арга хэмжээг зохион явуулж гэр бүлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан.

Цагдаагийн газраас Монголын Цагдаагийн байгууллагын түүхт 96 жилийн ой, Өвөрхангай аймаг дахь Цагдаагийн газар байгуулагдсаны 78 жилийн ойн баярын арга хэмжээг "Олон дов" амралтын газар зохион байгуулж, ахлагч бүрэлдэхүүнээс 3 алба хаагчид хугацааны цол нэмж, ажлын амжилтаараа хамт олноо манлайлан ажиллаж

байгаа алба хаагчдыг шагнаж урамшуулсан.

Аймгийн Засаг даргын "Хөрөнгө акталж, данснаас хасах, балансаас балансад шилжүүлэх тухай А/328 захирамжаар Сумдын Эрүүл мэндийн төвүүдээс актласан автомашинуудыг хүлээн авч 2017 оны 07 дугаар сарын 08-ны өдөр хэсгийн төлөөлөгч нарт хүлээлгэн өгөх ёслолын арга хэмжээ зохион байгуулсан ба уг арга хэмжээнд ахмад ажилтнуудаа урьж оролцуулсан.

"Цагдаагийн алба хаагч, ажилтны нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг хамгаалах хөтөлбөр"-ийн хүрээнд аймгийн Зонноз судлалын төвтэй хамтран алба хаагчдыг тарваган тахалын вакцинд хамруулсан. Мөн "Элэг бүтэн монгол" хөтөлбөрийн хүрээнд аймгийн Эрүүл мэндийн газраас Цагдаагийн газарт ажиллаж байгаа 40-өөс дээш насны алба хаагчдыг элэгний В, С вирусын үзлэг, шинжилгээнд хамруулсан.

Цагдаагийн газрын хэмжээнд нийт 39 ахмад настан харьяалагдаж байгаа бөгөөд цагдаагийн бэлтгэл хурандаа Ч.Бат-Очирыг төрийн дээд шагнал "Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон", цагдаагийн бэлтгэл дэд хурандаа Содномцэрэнг "Алтан гадас" одонгоор цагдаагийн бэлтгэл ахмад С.Александр, цагдаагийн бэлтгэл ахмад Б.Готовсүрэн нарыг "Цэргийн хүндэт медаль"-аар шагнуулах санал, тодорхойлолтыг аймгийн ИТХТ-ийн даргын нэр дээр албан бичгээр хүргүүлэв. Цагдаагийн бэлтгэл хурандаа Ч.Баточирыг ЦЕГ-ын "Цагдаагийн төлөө" тэмдэг, ЦЕГ-ын дэргэдэх Цагдаагийн ахмадын байгууллагын "Хүндэт тэмдэг"-ээр тус тус шагнуулсан.

Гурав. "Иргэдэд ойр эрх зүйн үйлчилгээний жил"-ийн төлөвлөгөөний хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил

Цагдаагийн байгууллагаас 2017 оны 2-р улиралд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 4 нэгдсэн арга хэмжээ /улсын хэмжээнд зохион байгуулсан 4, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсээс зохион байгуулсан 1/, 70 хэсэгчилсэн арга хэмжээ, 148 удаа нэгдсэн үзлэг шалгалтыг зохион байгуулж, үр дүнг тооцсон байна.

Эрүү, хэв журмын нөхцөл байдлын сар бүрийн мэдээнд үндэслэн цагдаагийн газрын криминологи судалгааны баг тогтмол хуралдаж, гэмт хэрэг, зөрчил дийлэнх гардаг Арвайхээр сумын багуудад тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "ЗАХ", "РС-1,2,3", "SCHOOL POLICE-1,2", "ХӨРШ АЙЛ", "ХӨРШ АЙЛ-2", "БАГ АЮУЛГҮЙ ОРЧИН", "ЗАХИРГААНЫ ХЯНАЛТ", "ХАМГААЛАХ БҮС", "СОГТУУ", "НИЙТИЙН ТЭЭВЭР", "ХУРД", "ХОТ ХООРОНДЫН ХЯНАЛТ", "СОГТУУ", "БАГ" "МОТОЦИКЛЬ", "ИРГЭН ТАНЫ ТӨЛӨӨ" гэх мэт нийт 70 удаагийн хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулсаны үр дүнд нийт гэмт хэргийн гаралт 18,4 хувиар, гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэргийн гаралт 40,7 хувиар тус тус буурсан эерэг үзүүлэлтүүд харагдаж байна.

Арга хэмжээний хүрээнд 10 олон нийтийн цагдаа, 16 урамшилт эргүүл, 1386 иргэн нийтийн эргүүлд ажиллаж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр аж ахуй нэгж байгууллагад 299 мэдэгдлийг хүргүүлэн, 205 мэдэгдлийн биелэлтийг газар дээр нь шалгаж, 288 мэдэгдлийн хариуг авч, 33579 санамж сэрэмжлүүлгийг тараан, захиргааны хяналтад байгаа 156 иргэнтэй уулзалт хийн, хууль эрх зүйн зөвлөгөө өгсөн.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сурталчилах зорилгоор "Амар

тайван гэр бүл” дэвжээ тэмцээнийг зохион байгуулсан.

Тэмцээнд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 22 байгууллагын 44 төрийн албан хаагч оролцож, 1, 2-р байр эзэлсэн багийг аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс шагнаж урамшуулсан.

Ухуулга, яриа, сургалт, сурталчилгаа: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа 94, уулзалт, хэлэлцүүлэг, ярилцлага 67, өдөрлөг 25, уралдаан, тэмцээн 37, нийт 224 удаа зохион байгуулж, 31651 иргэнийг хамруулсан байна.

Бичсэн мэдэгдэл, шаардлага, авсан хариу: Энэ хугацаанд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцлийг арилгуулахаар иргэн, хуулийн этгээдэд 299 мэдэгдэл өгч, 288 буюу 96,3 хувьд нь хариу авсан, 1 шаардлага өгч, 1 буюу 100 хувьд нь авч, 205 мэдэгдэл, шаардлагын биелэлтийг газар дээр нь шалгаж ажилласан. /Мэдэгдлийн мөрөөр торгууль ногдуулсан иргэн, аж ахуйн нэгж байгууллага одоогоор байхгүй болно./

Цагдаагийн газрын өдөр тутмын үйл ажиллагаа, “Олон нийт цагдаа”-ийн хамтын ажиллагаа, хүний нөөц, төсөв, санхүү төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, байгууллагын үйл ажиллагааг сурталчлахтай холбогдох харилцааг зохицуулах үүрэг бүхий “Ил тод байдлыг хангах, мэдээлэл сурталчилгааны ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг цагдаагийн газрын даргын А/70 дугаар тушаалаар баталж хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.

Мөн Цагдаагийн газрын алба хаагчдыг өдөр тутмын мэдээ мэдээллээр хангах зорилгоор Цагдаагийн газрын даргын А/60 дугаартай тушаалаар сурвалжлагч томилж тухайн өдөр болсон онцлох үйл явдлыг зургаар баримтжуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан.

Арвайхээр сумын замын тэмдэгний тооллого, тэмдэглэлийн судалгааг тус сумын мэргэжлийн багтай хамтран гаргалаа.

Замын цагдаагийн албаны дэд дарга, Техник, замын хяналтын хэлтсийн дарга, Техник хяналтын тасгийн дарга нарын хамтран баталсан “Тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, хуваарь”-ийн дагуу “Эвдрэл гэмтэл-техникийн зөрчил”, “Тээврийн хэрэгслийн гэрэлтүүлэх хэрэгсэл”, “Тээврийн хэрэгслийн өнгө, үзэмж”, “Ачааны автомашин-ачаа тээвэрлэлт” зэрэг хэсэгчилсэн арга хэмжээг хуваарийн дагуу зохион байгуулан ажиллаж, мэдээг хугацаанд нь хүргүүлсэн.

Орон нутгийн замд даац хэтрүүлэн ачаа тээвэрлэсэн том оврын ачааны автомашин зорчсоноос зорчих хэсэгт эвдрэл /овоолт, хонхойлт/ үүссэнээс зам тээврийн осол гарч болзошгүй байгаад анхаарч, дээрх тээврийн хэрэгслүүдийн хөдөлгөөнийг хязгаарлах, бодит жинг хэмжих зөөврийн жин хэмжүүрийг Тарнын пост дээр ажиллуулж байгаа нь үр дүнтэй ажил болоод байна.

Мөн зам тээврийн осол, хэрэг ихээр гардаг “Хар цэг”-үүдийн судалгааг нарийвчлан гаргаж, тухайн замд хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулж, жолооч нарт мэдээлэл өгөх зорилгоор тэмдэг тэмдэглэгээнүүд, болон хурд сааруулагч байрлуулуулан ажилласан байна.

Цагдаагийн газрын Uvurkhangai.police.gov.mn цахим хуудас болон tsagdaa.ukhgmail.com page хуудсанд цагдаагийн газрын алба хаагчдын үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллүүдийг тогтмол байршуулж иргэд, олон нийтэд сурталчлан ажилласан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн 1, 2 дахь шатны санал хураалтын үед цагдаагийн байгууллагаас хийж гүйцэтгэх ажлын нэгдсэн төлөвлөгөөг Цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэнийг хүлээн авч тус газраас хэрэгжүүлэх ажлын чиглэлээр салбар төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллав.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/146 дугаартай “Цагдаагийн бие бүрэлдэхүүнийг өндөржүүлсэн бэлэн байдлын нэгдүгээр зэрэглэлд шилжүүлж, ажиллуулах тухай” тушаалыг үндэслэн Цагдаагийн газрын даргын 2017 оны 07 дугаар сарын 06-ны А/76 дугаартай тушаалаар нийт бие бүрэлдэхүүнийг Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлэн ажиллуулах тухай тушаалыг төлөвлөн, дагаж гарах баримт бичиг, үүрэг, ажлын чиглэлийг боловсруулж бэлэн байдлыг хангаж ажиллав.

Тус аймагт сонгуулийн 108 хэсгийн хороо байгуулагдаж санал авах байранд хамгаалалтаар 83 алба хаагч, Баянгол дүүрэг дэх цагдаагийн 1, 2 дугаар хэлтсээс 25 алба хаагч нэмэгдлээр ажиллаж байгаа бөгөөд 108 хэсгийн хороонд саналын хуудас хүргүүлэх, явуулын хайрцагаар санал авах үеийн хамгаалалтын төлөвлөгөө, зураглалыг гарган баталгаажуулж төвд ажиллахаар үлдсэн эргүүл, харуул, жижүүрийн үйл ажиллагаанд хэлтэс, тасаг, хэсгийн дарга, ахлах байцаагч нар байнгын хяналт тавин ажиллаж байна.

Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцагаар санал санал хураалтыг авахаар 161 чиглэлд 153 автомашинтай явсан ажлын хэсгийн гишүүдийг зааварчилга, зөвлөмжөөр ханган санал авах байрны хамгаалалтад ажилласан алба хаагчдаас автомашины бүрэн бүтэн байдал, аюулгүй байдлыг үзэж шалгасаны дүнд хөдөлгөөнд оруулсан. Сонгуулийн санал авах байрны хамгаалалтыг зохион байгуулсан өдрүүдэд цагдаагийн газарт “Шуурхай штаб”-д 8 алба хаагч нөөцөд 53 алба хаагч бэлэн байдалд ажиллаж, санал авах өдөр Арвайхээр суманд байрлах 12 хэсгийн хороонд нэмэгдлээр ажиллуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж ажилласан байна.

Арвайхээр хот байгуулагдсаны 290 жилийн ой, Арвагар хээрийн Их хурд -2017, Хангайн бүсийн хурдан морины уралдаан, Монгол түмний морины их шүтээн”-ний 10 жилийн ойн баяр наадам 2017 оны 07 дугаар сарын 28, 29, 30-ны өдрүүдэд зохион байгуулагдахтай холбогдуулан Цагдаагийн газрын даргын 2017 оны 07 дугаар сарын 27-ний өдрийн А/89 дугаартай тушаал гаргаж сумдын цагдаа нарыг нэмэлтээр хамгаалалтанд ажиллуулсаны үр дүнд хамгаалалт хэвийн явагдсан. Энэхүү хамгаалалтанд 137 алба хаагч ажил үүрэг гүйцэтгэсэн ба сахилга хариуцлага алдаж зөрчил гаргасан алба хаагч байхгүй болно.

Дөрөв. “Эрх зүйн сургалт сурталчилгааны төлөвлөгөөний хүрээнд хийсэн ажил арга хэмжээ

2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэх гэж буй Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрлийн тухай хууль, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуулиуд хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан Хууль зүйн яамнаас зохион байгуулсан сургалтанд нийт 85 алба, хаагч хамруулсан. Шинээр батлагдан гарсан

журмуудыг тухай бүр нийт бүрэлдэхүүнд мэдээлж сургалт зохион байгуулж байна.

Цагдаагийн газрын хэлтэс, тасаг, хэсгийн төлөвлөгөөнд алба хаагчдаас шинэ санал санаачилга гаргаж ажиллах талаар тусгаж хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Алба хаагч солилцон туршлага судлах ажлын хүрээнд Замын цагдаагийн 2 алба хаагч Сонгинохайрхан дүүргийн Замын цагдаагийн хэлтэст, хэв журмын ахлах байцаагч, малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хэсгийн дарга нар Хэнтий аймгийн цагдаагийн газарт туршлага судалж ажилласан.

Мөн Цагдаагийн газрын ахмад ажилтан бэлтгэл цагдаагийн дэд хурандаа М.Чимэдрэгзэнг урьж алба хаагчдад өөрийн ажил амьдралын түүхэн замнал, сахилга ёс зүйн зөрчил гаргалгүй ажиллах, хүнтэй харилцах харилцааны талаар үнэтэй зөвлөгөө өгүүлж, дурсгалын зүйл гардуулав.

Цагдаагийн газрын даргын санаачилгаар алба хаагчдын мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалт зохион байгуулах “Хээрийн сургалт дадлагын төв” барих ажлыг эрчимжүүлж сургалтын төв барих газрын асуудалыг Тарагт сумын Засаг даргад албан бичиг хүргүүлж шийдвэрлүүлэн Цагдаагийн газрын даргын А/86 дугаар тушаалаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилж барилын ажлыг эхлүүлсэн ба барилын ажил 40 хувьтай хэрэгжиж байна.

Тав. Цаашид хэрэгжүүлэх ажлын талаар.

Түдгэлзүүлсэн хэргийн нөхөн илрүүлэлтийн хувийг ахиулах зорилгоор нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулж, үр дүнг тооцох

Гэмт хэрэг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг хөрш зэргэлдээ аймгийн болон бүсийн Цагдаагийн газар, хэлтэстэй хамтран зохион байгуулах, хамтын ажиллагааг сайжруулж, эрэн сурвалжлах ажлын үр нөлөөг дээшлүүлэх

Алба хаагчдын сахилга, хариуцлагыг сайжруулах зорилгоор удирдах болон ахлах ажилтнуудын шат дараалсан хяналтыг сайжруулж, манлайллыг дээшлүүлэх

Хууль сахиулах их сургуулийн эрдэм шинжилгээний мэргэжилтэнүүдээр Өвөрхангай аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн шалтгаан нөхцөл, нөлөөлөх хүчин зүйлс, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй судлуулж, үр дүнг цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ТАСГИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА

Д.ЭРДЭНЭБАТ

ХЯНАСАН: ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

О.ГАНБАТ

